



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/126

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 32.1.10, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоол”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор улсын нөөцөөс үнэгүй олгогдож байгаа тэжээлээс аймгийн аюулгүй нөөцөд тэжээлийн улаан будаа татан авахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хууль журмын дагуу гэрээ байгуулан ажиллаж, холбогдох зардал болох 9,140,000 (есөн сая нэг зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном) зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400305

Аймгийн Засаг даргын 2024 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн  
хавсралт



**“Тэжээлийн улаан будаа” татан авах зардал**

№	Зардал	Нэг бүр	Үнэ	Нийт
1	Вагоны хөлс	4 ш	995,000	3,980,000
2	Вагон доторлох зардал	4 ш	390,000	1,560,000
3	Шуудай /ирсэн хойно уутлах/	3,000 ш	1,200	3,600,000
	<b>Нийт</b>			9,140,000